

ХАМБА НОМУН ХААНЫ “УВДИСТ РАШААНЫ ДУСАЛ” СУДАРТ БУЙ
ХАНИАДЫГ ДАРАХ ЭМИЙГ ШИНЖЛЭХ НЬ

Б.Сумъяацэрэн¹, М.Шинэгэрэл², Г.Сумъяахорол³, Х.Улаан-Од⁴, Ш.Болд⁵

^{1,2,3}Эм Зүйн Шинжлэх Ухааны Их Сургууль,

⁴“Ач” АУИС

⁴Уламжлалт анагаах ухааны эрдэм судлалын хүрээлэн

Sumka070188@gmail.com

AN ANALYSIS OF THE ANTI-COLD MEDICINE IN THE KHAMBA NOMUN KHAN'S
“MAN NGAG BDUD RTSI ZEGS MA” SUTRA

Sumiyatseren B¹, Shinegerel M², Sumiyakhoro G³, Ulaan-Od H⁴, Bold Sh⁵

^{1,2,3}Mongolian University of Pharmaceutical Sciences

⁴“ACH” Medical University

⁵Traditional Medical Research Institute

Судалгаа, шинжилгээ

Abstract

Introduction: Luvsandanzanjantsan has written a total of 4 volumes, 79 collections and 220 classes in Tibetan, including 5 medical books. Luvsandanzanjantsan's “man ngag bdud rtsi zegs ma” sutra, which was the main research material for our study. We made it easier to start studying the “Root Tantra” of the “Four Medical Tantras”, a classic work of Indian and Tibetan medicine. “Four Medical Tantras” was the main guide for medical students of traditional medicine at that time. The book “man ngag bdud rtsi zegs ma” has 18 pages sutra from the many works written by Khamba Nomun Khan. He summarized his experience and lessons learned in differential treatment of fever, some of the most common diseases in women, medical care for 22 diseases such as wind, bile and phlegm, measles, mumps, gonorrhoea, edema, cold, and so on. We have studied the medicine treatment of colds from these treatments.

Purpose: Explain the meaning of the use of anti-cold medicine in the “man ngag bdud rtsi zegs ma” sutra by Lama Gegeen Luvsandanzanjantsan.

Methods: Methods of textual analysis for ancient books and analysis and synthesis were used in the study.

Conclusion: Luvsandanzanjantsan was not only a famous scientist who penetrated in many fields of knowledge, but also expanded the research work of Mongolian medicine and became the first Mongolian doctor to study medicine in outer Mongolia. There are three parts in the “man ngag bdud rtsi zegs ma” sutra by Lama Gegeen Luvsandanzanjantsan. For treatment to the anti-cold, Mana-4 tan and Norov-7 tan are used in preliminary stage, Tuglogunsel, Tushmel-3, Gajid-9, Erkhem-8, Gurgem-7, Rinchenshagba and Uvsun em-11 are used in hot stage.

Keywords: Luvsandanzanjantsan, sutra, anti-cold medicine

Үндэслэл

ХҮИ зууны үеэс эхлэн Монгол салбарыг багтаасан тусгай зохиол, Сүмбэ эмч нар тухайлбал Ламын гэгээн хамба Ишбалжирын “Дөрвөн рашаан”, эмийн Лувсанданзанжанцангийн туурвисан анагаах судлалын тусгай зохиол Жамбалдоржийн ухааны эмчилгээ болон эм, найрлагын “Үзэсгэлэнт нүдэн чимэг”, эм найрлагын ухааны

тусгай зохиол Жамбалчойжиданзанпэрэнлэйн “Увдисын далай” зэргийг дурдаж болно. Үүнээс гадна эмт бодисыг зөв таних арга ухаан, эмийн түүхий эдийн хоруу чанарыг гаргах буюу номхотголын арга, өвчний мөн чанарыг оновчтой оношлон тогтоох эмчийн туршлага, газар газрын эмч нарын өөр өөрийн овор төрхийг хадгалсан жорын судар, эмчилгээний бас бус арга туршлага энэ бүхэн нийлээд Монгол анагаах ухааны шинж чанарыг агуулсан нэгэн цогц бүтээлүүд болох юм. Энэ бүхнээс Монгол анагаах ухааны онол, эмчилгээний арга туршлага бүрэлдэн гарсан гэж хэлж болно. Одоо гагцхүү бүтээл, туурвил ихтэй, олноос онцгойрон гарсан нэрт эмч нарын намтар, зохиолыг судлан тогтоож, онол, практик, танин мэдэхүйн ач холбогдлыг нь гаргах нь чухал болоод байна.

Иймд бид Ламын гэгээн Лувсанданзанжанцангийн намтар, түүхэнд холбогдох зарим эх сурвалж, баримтууд, анагаах ухааны ном судрыг судлан судалгааны эргэлтэнд оруулах, сургалт, судалгаанд ашиглах, олны хүртээл болгохоор энэхүү сэдвийг сонгон авлаа.

Судалгааны ажлын зорилго: Ламын гэгээн Лувсанданзанжанцангийн “Увдист рашааны дусал” сударт буй ханиадыг эмчлэх эмийн хэрэглээний утганд тайлбар хийх.

Судалгааны ажлын зорилт

1. Ламын гэгээн Лувсанданзанжанцангийн намтрыг тодруулах.
2. Ламын гэгээн Лувсанданзанжанцангийн “Увдист рашааны дусал” бүтээлийн агуулга, бүтцийг шинжлэх.
3. “Увдист рашааны дусал” сударт буй ханиадыг эмчлэх эмийг түүвэрлэн хэрэглээний утганд тайлбар тайлал хийх.

Судалгааны материал ба арга

Судалгааны ажлын материал: Ламын

гэгээн Лувсанданзанжанцан ᠰᠤᠯᠠᠮ ᠤᠨ ᠳᠠᠨᠵᠢᠨ ᠵᠢᠨᠵᠢᠨ ᠵᠢᠨᠵᠢᠨ Модон барын төвөд судар¹. (Хувийн цуглуулга)

Судалгааны арга

1. Эх бичиг, сурвалж бичгийн судалгааны арга: Бид судалгаандаа энэхүү аргыг ашигласан Ламын гэгээн Лувсанданзанжанцангийн намтар болон түүний зохиосон “Увдист рашааны дусал” бүтээлийн гол агуулга, бүтцийг тодруулав.
2. Анализ-синтезийн арга: Задлан шинжлэх, нэгтгэн дүгнэх арга. Анализ нь задлах, ялгаж салгах гэсэн утгатай бөгөөд судлаач сонгож авсан объект буюу үзэгдэл юмыг өөрийн сэтгэхүйгээр тодорхой бүрэлдэхүүн хэсгүүдэд ангилна. Ингэснээр тухайн объектын хийсвэрлэж болох үндсэн шинж чанарууд тодорхой бүрэлдэхүүн хэсгүүд дээр илүү тод илэрч гарна. Анализ хийх нь объектыг задлан шинжилснийг шууд дагалдан зайлшгүй хийгддэг сэтгэхүйн логик үйлдэл юм. Энэхүү аргаар Ламын гэгээн Лувсанданзанжанцангийн “Увдист рашааны дусал” сударт байгаа ханиадыг эмчлэх эмийн хэрэглээний утгыг нээн гаргах задлан шинжилж судлав. Задлан шинжилж гарсан үр дүнг нэгтгэн дүгнэх замаар анализ-синтезийн аргыг ашиглав.

Судалгааны үр дүн

Лувсанданзанжанцан машид гарсан XI жарны “согтох төгөлдөр” хэмээх шороон эм туулай жилийн (1639 он) хаврын тэргүүн сарын 15-нд Сайн ноён хан аймгийн Өлзийт овоо (одоогийн Өвөрхангай аймгийн Хангай ханы орчим) гэдэг газар мэндэлжээ. Түүний эцэг Лояг эрх Чөхүр нь Чакраварди хаан хэмээн алдаршсан Их богд эзэн Чингис хааны 27 дугаар үе, Батмөнх даян

орчуулга байхаас гадна цээжилэхэд хялбар болох нь тогтоогдож байна. Тухайлбал:

Хямарсан халууны эмчилгээг
Халуун бүхнийг арилгагч
Хонлэн, банздоо, балига, гурван үр
Хойтой, бас жуган, мана, сороол,
мэхээр найруулж
Ханиад, уушгины хямраан талхыг өгвөл
Хямарсан хуучин ханиадны урхаг
Хөх цайвар цэр гарах ба

Амьсгал амаргүй болох тэргүүтнийг

Амарлиулахад тустай хэмээмүй гэсэн байдаг. Энэхүү шүлэглэсэн орчуулгад дандаа “х” үсгээр толгой холбосноос гадна шинж тэмдэг, өвчний оношийг хамтатган гаргасан байна. Энэ жоронд нийт 11 хөл эм орсон ба бүгдийг нь дараалуулан багтаасан нь сонирхолтой. Дараагийн жорыг 5 мөрөнд багтаан уудаг бус хамраар татдаг эмийг:

Хоёр зүйлийн арвай, бугын өөхтэй
найруулж
Хамрын нүхээр нь сайтар утваас
Хамрын ханиад хурдан арилна.
Манабатар, сэрдэг арүр найруулсан
талх
Магад ханиад томууг арилган чадюу
хэмээн шүлэглэжээ.
Хүүхэд, нялхсын ханиадад үндсэн эм
түшмэл гурав дээр хэрхэн нэмэр тавихыг
тодорхой дурдсан.

Хэрвээ энэ жороор эмчилж чадахгүй бол өөр ямар хувилбар байдгийг, хавсарсан эм болох гурван сэрүүн, мэхээр, сороолтой найруулбал дэм өгөхөөс гадна ямар сэтгэл засал хийхийг заасан байдаг. Үүнд:

Хүүхэд нялхсын халуунд түшмэл гурав тустай
Хүйтний хувь их бөгөөс даль нэмнэ

Хэрэв эс эдгэрвээс тунгалаг тав ч
тустай
Уушгины халуун ханиаданд гурван
сэрүүн
Үхэр мэхээр, сороолтой найруулж

өгвөөс дэмтэй

Хүүхдийн адад таван сахиусны
Тахил тавиулж, уншлага уншуул гэжээ.
Хоолойн хижиг дагшуурын шалтгаан нь
ерийн хижиг лугаа адил байдаг.

Нөхцөл нь бузар буртаг, халдварт хөлс зэргийг үнэртэх, айж цочих, нойр тэнцвэргүй болох, хүйтэн ус их уусан зэргээс болдог. Ялгавал: хий, шар, бадган, хурмал, хоолойн, уушгины, хижгийн, хамрын дагшуур зэрэг найм буй. Шинж нь найтаалгах, хамраас шингэн нус гоожих, хоолой багалзуур халуу оргиж хаагдах зэрэг болно гэж “Анагаах заслын рашааны ундралын гишүүнээс гарын авлагыг цөөлөн хураасан рашааны цагаан шүүдэр хэмээх оршвой” сударт бичжээ⁶. Энэ өвчний эмчилгээг Ламын гэгээн дараах байдлаар илэрхийлжээ.

Бөөрөнхий ар үр, мана, гүгэл, банзи,
манчэн
Бүдүүн мэхээр, хонлэн, сороол, дагшийг
найруулж
Хүчин төгс хөх гарьд ес хэмээгчээр
Хижиг, хямарсан нян халуун хийгээд
Хоолойн хижиг томуу бүхний рашаан
мөн хэмээжээ.

Мөн эс боловсорсон халууны үеийн бадган давамгайлсанд Мана-4 тан, шар давамгайлсанд Норов-7 танг өнөх, дэлгэрсэн халууны үед Гүргэм-7, Эрхэм-8, Ринчэншагба, Өвсөн эм-11 зэргээс өгөх, хоосон халууны үед гоньд, агар, руда, бойгар, задь, жуган, гүргэм, сармисны үнс, лидэр, туулайн зүрх, гандагарь зүрхэн шошын талхыг ясны шөлөөр даруулж уулгана⁷ хэмээжээ.

Дүгнэлт

1. Ламын гэгээн Лувсанданзанжанцан таван ухаанд нэвтэрсэн эрдэмтнээр барахгүй Монгол анагаах ухааны эрдэм судлалын ажлыг өргөжүүлэн улмаар анагаах ухааныг сурч эзэмшсэн анхны монгол эмч, Энэтхэг, Төвөдийн

эрдэмтдийн шилдэг бүтээлүүдэд дүгнэлт, тайлбар хийсэн хүн юм.

2. Ламынгэгээн Лувсанданзанжанцангийн “Увдист рашааны дусал” бүтээл нь мөргөлийн хэсэг, гол хэсэг болон төгсгөл гэсэн үндсэн 3 хэсэгтэй, нийт арван найман хуудастай ном бөгөөд гол хэсэгтээ хий, шар, бадган, бор, эс шингэсэн, бэтэг, хаван, халуун унгирал, эрхтэн, цул, сав, хэсэг бусаг зэрэг 22 өвчинд үзүүлэх эмнэлгийн тусламж, эмэгтэйчүүдэд зонхилон тохиолддог зарим өвчнүүд, халууныг ялган эмчлэх өөрийн туршлага, сургамжаа дүгнэн бичжээ.
3. “Увдист рашааны дусал” бүтээл дэх ханиадыг анагаах эмд: хямарсан хуучин ханиадны урхаг, хөх цайвар цэр гарах ба амьсгал амаргүйд Уушгины хямраан талхыг өгөх, хамрын ханиадад хоёр зүйлийн арвайг бугын өөхтэй найруулж хамрын нүхээр нь утах, хүүхэд, нялхсын ханиадад үндсэн эм Түшмэл-3 дээр эм нэмэрлэж уулгах, хоолойн хижиг томууд Хөх гарьд-9, халууны эхэн үед Мана-4 тан Норов-7 тан, дэлгэрсэн халууны үед Гүргэм-7, Эрхэм-8, Ринчэншагба, Өвсөн эм-11 зэргээс тус тус уулгана.

Ном зүй

1. Болд Ш, Цэрэнсодном Д. Монголын уламжлалт анагаах ухааны дээж бичиг. Улаанбаатар, Адмон ХК, 2013, х. 153-284
2. “Анагаах ухааны дөрвөн үндэс”. Найруулан орчуулсан Шин Хэлин. Үндэсний хэвлэлийн хороо. Бээжин. 2007
3. Анагаах ухааны язгуур үндсийн тайлбар тодруулагч зул. Төвөд хэлнээс орчуулсан Б.Болдсайхан. УБ, 2019
4. Ламын гэгээн Лувсанданзанжанцан མཁུ་ཚེན་ཚོས་ གྱི་རྒྱལ་པོའི་གསུང་འབུམ་ལས་མན་ངག་བདད་རྩི་ཟེགས་མ་བཞུགས་པོ། Модон барын төвөд судар.
5. “Анагаах ухааны дөрвөн үндэс”. Найруулан орчуулсан Шин Хэлин. Үндэсний хэвлэлийн хороо. Бээжин. 2007
6. Дөрвөн рашаан. Орчуулсан Жамбалшонну. ӨМАХХ, Хөх хот, 1998, х.146
7. Монгол отчийн таван зохиол. Орчуулсан Намжил. ӨМШУТМХХ. Улаан хад хот, 2014. х. 58-60

*Уншин танилцаж, нийтлэх санал өгсөн:
АШУ-ы доктор, профессор
Ч.Чимэдрагчаа*